



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

“Гэр даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн хөрөнгийн
хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Гэр даатгал” ХХК-ийн нэмж гаргасан нэг бүр нь 1000 /нэг мянган/ төгрөгийн үнэ бүхий 750,000 /долоон зуун тавин мянган/ ширхэг хувьцаанаас бүрдэх 750,000,000 /долоон зуун тавин сая/ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд тус компанийн хувь нийлүүлэгч “Вектор интернэшнл” ХХК-иас нэмэгдүүлэн дараах байдлаар өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
	Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
“Вектор Интернэшнл” ХХК	2,000,000,000.0	750,000,000.0	2,750,000,000.0	100
Нийт	2,000,000,000.0	750,000,000.0	2,750,000,000.0	100

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2014 оны 4 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Гэр даатгал” ХХК /Г.Баттогтох /-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000000